ҮНДЭСНИЙ АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: “ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

**ДҮГНЭЛТ: ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БАТАЛЖ МӨРДҮҮЛСНЭЭР ТӨСВИЙН АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ, ҮР АШИГТАЙ ЗАРЦУУЛАЛТЫГ “ДЭМЖИХ” ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРДСЭН БОЛОВЧ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ БҮРЭН ХАНГАГДАХГҮЙ БАЙНА**

2025 оны 06 дугаар сар

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 20 өдөр Дугаар А/62 Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус хүргүүлэхийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (С.Батбямба), олон нийтэд мэдээлэхийг Тамгын дарга, тэргүүлэх аудитор (Б.Бундхорол) нарт тус тус даалгасугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд (Г.Занданшатар), Сангийн сайд (Б.Жавхлан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д даалгасугай.

5.Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д даалгасугай.

6.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын баримтыг хадгаламжийн нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг Эрсдэлийн удирдлагын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.

С.МАГНАЙСҮРЭН

Z:\Tushaal\2025\EA-In A Tushaal\0620 SNAG-1.Docx

1525010?73

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2025 оны 06 сарын 20-ны өдрийн
А/62 тушаалын хавсралт

ЗГ-ын тогтоолоор 2021-2023 онд барьцааны дансанд байршуулсан хөрөнгө оруулалтын зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

| Д/д | Тогтоолын дугаар | ТЕЗ-ийн нэр | Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал | Үлдэгдэл /2025.05.15-ны өдрийн байдлаар/ |
|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | |
| 1 | ЗГ-ын 2021 оны 397 дугаар тогтоол | Боловсролын сайд | XIII.1.2.20 | Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 3 дугаар цэцэрлэг, "А" байр/ Цэцэрлэгийн барилгын их засвар | 50,788,247.00 |
| 2 | ЗГ-ын 2022 оны 495 дугаар тогтоол | Боловсролын сайд | XIII.1.2.12 | Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, 1 дүгээр цэцэрлэг/ | 20,000,000.00 |
| 3 | ЗГ-ын 2022 оны 495 дугаар тогтоол | Боловсролын сайд | XIII.1.2.13 | Цэцэрлэгийн барилгын их засвар /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон, Янзагахан цэцэрлэг/ | 49,268,100.00 |
| | | Дүн | | | 120,056,347.00 |
| 4 | ЗГ-ын 2021 оны 397 дугаар тогтоол | УИХ-ын Тамгын газар | II.3.1 | Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж, программ хангамж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 113,801,207.00 |
| 5 | ЗГ-ын 2022 оны 495 дугаар тогтоол | УИХ-ын Тамгын газар | II.3.1 | Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж, программ хангамж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ /барьцаа/ | 74,647,358.00 |
| 6 | ЗГ-ын 2022 оны 495 дугаар тогтоол | УИХ-ын Тамгын газар | II.3.1 | Улсын Их Хурлын Тамгын газрын тоног төхөөрөмж, программ хангамж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ /барьцаа3/ | 250,296,295.00 |
| | | Дүн | | | 438,744,860.00 |
| 7 | 2021-397 тогтоол | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам | XII.1.114 | "Жишиг хороолол" төсөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ | 22,723,311.00 |
| 8 | 2021-397 тогтоол | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам | XII.2.45 | Нийтийн эзэмшлийн байруудын дулаалга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 4, 8, 17 дугаар хороо/ | 16,774,838.00 |
| 9 | 2021-397 тогтоол | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам | XII.4.9 | Дэд бүтэц, шугам сүлжээний ажлуудын зураг төсөв /Улаанбаатар, Налайх дүүрэг/ | 480,665.00 |
| 10 | 2023-456 тогтоол | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам | IX.1.69 | Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/ Сумын төвий тохижилт /Увс, Улаангом сум, 12-р баг/ | 70,673,050.00 |
| 11 | 2023-456 тогтоол | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам | IX.1.69 | Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум/ Сумын төвийн тохижилт /Увс, Улаангом сум, 7-р баг/ | 40,797,661.00 |
| 12 | 2023-456 тогтоол | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам | IX.4.1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/ Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ажиллах усан цэнэгт цахилгаан станцын ТЭЗҮ боловсруулах | 45,701.68 |
| 13 | 2023-456 тогтоол | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /Нийслэл/ | IX.1.33 | Барилга, хот байгуулалтын салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа загвар төсөл | 209,500,000.00 |
| 14 | 2023-456 тогтоол | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /Нийслэл/ | IX.1.33 | Барилга, хот байгуулалтын салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа загвар төсөл | 541,188,915.00 |
| 15 | 2022-495 тогтоол | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам /Нийслэл/ | XII.1.28 | "Жишиг гудамж" төсөл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ | 323,196,107.00 |
| | | Дүн | | | 1,225,380,248.68 |
| 16 | 2024 оны 351 дүгээр | Эрдэнэс Монгол нэгдлийн харьяа Цемент шохой ХХК | - | Эрдэнэс Монгол нэгдлийн харьяа Цемент шохой ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс тогтоосон 3,471,564,110.0 /гурван тэрбум дөрвөн зуун далан нэгэн сая таван зуун жаран дөрвөн мянга нэг зуун арав/ төгрөгийн ногдол ашгийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй. | 3,471,564,110.00 |
| | | Дүн | | | 3,471,564,110.00 |
| | | Нийт дүн | | | **5,255,745,565.68** |
| | | | Албан шаардлага | | |
| Д/д | | Шалгагдагч байгууллагын нэр | Гаргасан шийдвэр | Зөрчлийн утга | Мөнгөн дүн |
| 17 | | ТӨБЗГ | Албан шаардлага | ТӨБЗГ-ын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 1,200.0 сая төгрөгийн "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн систем, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ" тусгагдсан бүрэн дуусаагүй ажлыг санхүүгийн тайланд тусгахдаа Барилга байгууламжийн дансанд бүртгэсэн. | 1,200,000,000.00 |
| | | Дүн | | | 1,200,000,000.00 |
| | | Нийт дүн | | | 6,455,745,565.68 |

## АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

Эрсдэлийн удирдлагын газар

Газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Отгонбаяр

Менежер: Н.Анхбаяр

Ахлах аудитор: Ж.Энхтуяа, О.Баярмаа

Аудитор: Ү.Төгсжаргал, П.Норпил, О.Нандинцэцэг

Шинжээч Б.Мягмаржав, Ц.Галбадрах

Улаанбаатар хот

2025 он


| | |
|---|---|
| Товчилсон үг | 3 |
| Хүснэгтийн жагсаалт<br>Хавсралтын жагсаалт<br>Дүрслэлийн жагсаалт | 4 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл | 5 |
| Ерөнхий мэдээлэл | 6 |
| **БҮЛЭГ 1** Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалтыг хангах зарчмууд бүрэн хэрэгжихгүй байна | 8-17 |
| **БҮЛЭГ 2** Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим зүйл, заалт төсвийн тухай хуулийн зарим зохицуулалттай давхардаж байгааг хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлж боловсронгүй болгох шаардлагатай байна | 18-25 |
| **БҮЛЭГ 3** Засгийн газар болон түүний харьяа байгууллагууд төрийн хэмнэлтийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлээгүй, хяналт тавьж ажиллаагүй байна | 26-28 |
| Аудитын дүгнэлт | 29 |
| Аудитын зөвлөмж | 30-31 |
| Хавсралт | 39-58 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| ААТҮГ | Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| АЗЗА | Авто зам засвар арчлалт |
| БГД | Баянгол дүүрэг |
| БНД | Багануур дүүрэг |
| БС | Боловсролын сайд |
| БШУС | Боловсрол шинжлэх ухааны сайд |
| ДТГ | Дипломат төлөөлөгчийн газар |
| ДЦС | Дулааны цахилгаан станц |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗГХЭГ | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар |
| МТС | Мэдээллийн технологийн сүлжээ |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ОХУ | Оросын  Холбооны Улс |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| ТАГ | Төрийн аудитын газар |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ТБОНӨ | Төрийн болон орон нутгийн өмчит |
| ТӨААТҮГ | Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТӨХК | Төрийн өмчит хувьцаат компани |
| УБЦТС | Улаанбаатар цахилгаан түгээх станц |
| УИХ | Улсын Их Хурал |
| УТҮГ | Улсын төсөвт үйлдвэрийн газар |
| ЦДАШ | Цахилгаан дамжуулах агаарын шугам |
| ЦДҮС | Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ |
| ЦХИХХС | Цахим хөгжил,  инновац, харилцаа холбооны сайд |
| ШУТИС | Шинжлэх ухаан технологийн их сургууль |
| ХК | Хувьцаат компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ЭХЯ | Эрчим хүчний яам |

## Хүснэгтийн жагсаалт

ГАРЧИГ


| | | |
|---|---|---|
| Хүснэгт 1 | УТХО-ын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан үлдэгдэл | 18 |
| Хүснэгт 2 | Гэрээний мэдээлэл байршуулаагүй төсөл, арга хэмжээний судалгаа | 19 |
| Хүснэгт 3 | Шууд худалдан авалт зохион байгуулсан 2022-2024 оны төлөвлөлтийн судалгаа | 24 |


## Хавсралтын жагсаалт


| | | |
|---|---|---|
| Хавсралт 1 | Аудитын түүвэрт хамрагдсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн 2022 онд чөлөөлсөн удирдах ажилтны жагсаалт | 37-38 |
| Хавсралт 2 | Хууль тогтоомжийг зөрчиж хяналтын менежер болон бүтээмж хариуцсан менежер томилсон жагсаалт | 39-40 |
| Хавсралт 3 | Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу 2022 онд татан төвлөрүүлсэн автомашины судалгаа | 41 |
| Хавсралт 4 | Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу 2023 онд төвлөрүүлсэн автомашины судалгаа | 42-43 |
| Хавсралт 5 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй ялгагдах дугаар хэрэглээгүй авто машинуудын судалгаа /2024 оны байдлаар/ | 44-46 |
| Хавсралт 6 | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ажиллаж байгаа албан хаагчдын судалгаа | 47-48 |
| Хавсралт 7 | Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажилд дэмжлэг үзүүлсэн жагсаалт | 49-50 |
| Хавсралт 8 | ТЕЗ-чдын батлагдсан төсвийг дутуу зарцуулан улсын төсөвт 2022-2024 онд буцаан төвлөрүүлсэн дүн | 51-53 |
| Хавсралт 9 | Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлийн мэдээлэл | 54-55 |
| Хавсралт 10 | Аудитын илрүүлэлт, шийдвэрийн нэгтгэл | 56-57 |


## Дүрслэлийн жагсаалт


| | | |
|---|---|---|
| Дүрслэл 1 | 2025 онд шинээр хэрэгжих, төсөл арга хэмжээ | 18 |
| Дүрслэл 2 | Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүд хуулийн заалтаар /сая.төгрөг/ | 25 |
| Дүрслэл 3 | Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүд хуулийн заалтаар /сая.төгрөг/ | 25 |
| Дүрслэл 4 | Аудитын 2022-2024 оны илрүүлэлт | 26 |
| Дүрслэл 5 | Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн зөрчил | 26 |

## ТӨРИЙН АУДИТЫН СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

### Аудит хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэв.

### Аудитын зорилго, хамарсан хүрээ:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан эсэх;
- Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан эсэх;
- Засгийн газар болон бусад төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан эсэх.

Аудитад Монгол Улсын 2022, 2023 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022-2024 онд хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа зарим байгууллагууд болон холбогдох бусад байгууллагыг түүвэрт хамруулан тус төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, баримт материалын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Мөн төсөв захирагч нарын 2025 оны 6 сар хүртэл хэрэгжүүлсэн зохион байгуулалтын зарим арга хэмжээг аудитад хамруулсан болно.

### Аудитын хязгаарлалт:

Хууль, хяналтын байгууллага болон шүүхээр хянан хэлэлцэгдэж буй асуудал, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудитаар шалгасан асуудлыг аудитад хамруулаагүй болно.

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу шалгагдагч этгээд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомж, бусад журмын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг дүгнэн, аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулах, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч С.Батбямба, Эрсдэлийн удирдлагын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Отгонбаяр нар хянан удирдаж, менежер Н.Анхбаяр үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Энхтуяа, О.Баярмаа, аудитор Ү.Төгсжаргал, П.Норпил, О.Нандинцэцэг, шинжээч Б.Мягмаржав, Ц.Галбадрах нар хийж гүйцэтгэсэн.

### Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд:

Аудит гүйцэтгэх хугацаа богино, хүний нөөцийн дутмаг байдал, төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь бодлогын шийдвэр гаргах нөхцөлийг алдагдуулж, хүндрэл учруулж байсан.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурал Төрийн хэмнэлтийн тухай хуулийг төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан байна. Хууль батлагдсанаас хойш 2022 онд 1 удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Хуулийг дагаж мөрдөх, хэрэгжүүлэхтэй холбогдуулан УИХ-ын 2022 оны “Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 72 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт чиглэл өгч, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосон.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 6517 байгууллагыг хамруулан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, 61,600.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, төлбөрийн акт тогтоон, албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгч ажилласан байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 2,735,200.0 сая төгрөгийн урсгал зардлаас 2,598,200.0 сая төгрөгийг зарцуулж, 53,800.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй, улмаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн 83,200.0 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар 38 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх 92 хөтөлбөр 309 арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 16,949,900.0 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

ТЕЗ-дын хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 21 арга хэмжээний хэрэгжилт 10.0-50.0 хувь, 9 хөтөлбөрийн 28 арга хэмжээний хэрэгжилт 50.0-80.0 хувь, 72 хөтөлбөрийн 257 арга хэмжээний хэрэгжилт 80.0-100.0 хувийн гүйцэтгэлтэй тайлант онд хэрэгжсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитад 6711 байгууллагыг хамруулан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 56,800.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, төлбөрийн акт тогтоон, албан шаардлага хүргүүлж, зөвлөмж өгч ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитад 1784 байгууллагыг түүвэрт хамруулан нийт 91,053.1 сая төгрөгийн 416 зөрчил илрүүлж, 5,509.0 сая төгрөгийн 91 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 32,916.3 сая төгрөгийн 97 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 52,627.8 сая төгрөгийн 228 зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

Батлагдсан төсвийг 2022 онд 83,200.0 сая төгрөг, 2023 онд 122,800.0 сая төгрөг, 2024 онд 356,163.4 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн бодитой үр дүн гарч, хэмнэлт өмнөх оноос өссөн байна.

## БҮЛЭГ 1 ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТӨСВИЙН САХИЛГА БАТ, ҮР АШИГТАЙ ЗАРЦУУЛАЛТЫГ ХАНГАХ ЗАРЧМУУД БҮРЭН ХЭРЭГЖИХГҮЙ БАЙНА

1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1[1]-д заасны дагуу 2022 онд 159 тэргүүн дэд, дэд, орлогч дарга гэсэн орон тоог чөлөөлж төсөвт байгууллагууд 3,900.0 сая төгрөг, түүвэрт хамрагдсан ТБОНӨ-т хуулийн этгээдүүд 39 орон тоог чөлөөлж 1,382.7 сая төгрөг, нийт 5,282.7 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бусад зардлыг хэмнэсэн байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт 1-д үзүүлэв)*

1.2 Гэтэл Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4[2] дэх заалтыг зөрчин “...*төрийн өмчит хуулийн этгээдийн бүтэц, зохион байгуулалтад засаглал, ил тод байдал, комплаенсийн болон гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод аудитын хяналт хариуцсан удирдлагын чиг үүргийг бий болгож, холбогдох хуульд заасан журмын дагуу шаардлага хангасан эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг*..” даалгаж, ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А-1/2076 дугаар албан бичгээр “*Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд... хяналт хариуцсан удирдлагын чиг үүргийг бий болгон төлөвлөн ирүүлэх*” чиглэл хүргүүлсэн байна.

1.3 Дээрх үүрэг, чиглэлийн дагуу төрийн өмчит хуулийн этгээдүүд 2025 оны 06 дугаар сарын байдлаар тэргүүн дэд, дэд, орлогч, зөвлөхийн албан тушаалтай ижил эрх, үүрэг бүхий удирдах албан тушаалын хяналтын менежер, бүтээмж хариуцсан менежер зэрэг өөр нэршилтэй нийт 42, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд 11 орон тоог бий болгон шинээр томилсон байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт 2-д үзүүлэв)*

1.4 Мөн 2024 оны байдлаар 3 аймгийн Засаг дарга захирамж гаргаж Засаг даргын орлогчийг ажлаас чөлөөлсөн боловч өмнөх чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий орон тоог шинээр бий болгож, шилжүүлэн томилжээ. Үүнд:

- Баян-Өлгийн ЗДТГ-т Засаг даргын зөвлөх;
- Төв аймгийн ЗДТГ-т Засаг даргын зөвлөх;
- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗДТГ-т Захирагчийн ажлын албаны орлогч дарга.

1.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын дагуу ТӨБЗГ нь 2022 онд төрийн болон төрийн өмчийн оролцоотой 122 байгууллагаас нийт 12,056.5 сая төгрөгийн үнэлгээтэй 150 автомашиныг хураан авч, хэрэгцээтэй гэж үзсэн байгууллага, нэгжүүдэд дахин хуваарилж, 5,225.7 сая төгрөгийн үнэлгээтэй 179 автомашиныг дуудлага худалдаагаар борлуулж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлжээ. *(Дэлгэрэнгүйг хавсралт 3-д үзүүлэв)*

1.6 Мөн тус тогтоолын дагуу ТӨБЗГ-аас 2023 онд төрийн болон төрийн өмчийн оролцоотой 90 байгууллагаас 5,043.5 сая төгрөгийн үнэлгээтэй 91 автомашиныг хурааж, орон нутгийн байгууллагуудаас 2,184.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 авто машиныг тус тус хураан авч, хэрэгцээтэй гэж үзсэн байгууллагуудад дахин хуваарилсан байна. Тус онд дуудлага худалдаагаар төрийн болон төрийн өмчит байгууллагуудаас 125.1 сая төгрөгийн 11 авто

[1] Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн болон орон нутгийн өмчийн их сургууль, төрийн өмчийн оролцоотой нэалттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно.

[2] 5.4.Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно.

машиныг дуудлага худалдаагаар борлуулж орлогыг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт 4-д үзүүлэв)*

1.7 Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн аудитын нэгтгэсэн дүнгээр хот дотор автомашин ашиглахыг хориглосон хязгаарлалтыг зөрчиж 2022 онд 118 албан хаагч, 1,115.6 сая төгрөг, 2023 онд 50 албан хаагч, 348.1 сая төгрөг, 2024 онд 47 албан хаагч 450.3 сая төгрөгийн шатахуун, үйлчилгээний төлбөрийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1[3], 6.2[4], 6.3[5]-т тус тус заасантай нийцэхгүй байна.

**Нийслэл:**

- Нийслэлийн 4 байгууллагын 29 удирдах албан тушаалтан албан хэрэгцээнд автомашинаар үйлчлэх гэрээний дагуу суудлын автомашиныг ашиглаж, үйлчилгээний төлбөрт 308.8 сая төгрөгийг зарцуулсан;

**Баян-Өлгий:**

- Аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн дарга, санхүүгийн ажилтнууд суудлын автомашин ашиглаж 1188 литр буюу 3.3 сая төгрөгийн шатахуун, Эрүүл мэндийн газар 2 суудлын автомашины шатахууны зардалд 1.3 сая төгрөг, нийт 4.6 сая төгрөгийг зарцуулсан;

**Дундговь**:

- Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга суудлын автомашин ашиглаж, шатахууны зардалд 2.7 сая төгрөгийн зарцуулсан;

**Сүхбаатар:**

- Аймгийн Засаг даргын орлогч, төрийн байгууллагын удирдлагууд Улаанбаатар хотод албан томилолтоор ажиллахдаа томилолт, шатахууны зардалд 20.8 сая төгрөг зарцуулсан байна.

1.8 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4[6]-д төрийн байгууллагууд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэхээр заасан байхад 2024 оны байдлаар төрийн өмчит 328 хуулийн этгээдийн хөрөнгөд бүртгэлтэй 2,056 авто тээврийн хэрэгсэл, аймаг, нийслэлийн 1,471 байгууллагын 6,807 авто тээврийн хэрэгсэл, нийт 8863 авто тээврийн хэрэгсэл улсын дугаар солиогүй байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт 5-д үзүүлэв)*

1.9 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д "*Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална*." гэж заасны дагуу Засгийн газрын 2022 оны Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 203 дугаар тогтоолоор ТӨБЗГ-т "*Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах санал боловсруулж, 2022 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх...*" гэж үүрэг болгосон хэдий ч тухайн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

1.10 Нийслэл, дүүргийн зарим албан хаагчдыг 2024 онд гадаад улсад албан томилолтоор ажиллуулахдаа үндэсний агаарын тээвэрлэгчийг бус бусад агаарын тээвэрлэгчийг сонгон үйлчлүүлж, нийт 1,312.7 сая төгрөгийн тасалбарыг худалдан авч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т[7] заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

---

[3] Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

[4] Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

5 6.3.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.

6 Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.

[7] Энэ хуулийн 3.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ.

- Нийслэлийн СХД-ийн ЗДТГ 364.7 сая төгрөг, ИТХ 5.5 сая төгрөг, СБД-ийн ЗДТГ 313.9 сая төгрөг, ИТХ 147.0 сая төгрөг, Нийслэлийн ЗДТГ 244.3 сая төгрөг, БГД-ийн ЗДТГ 135.7 сая төгрөг, ИТХ 84.0 сая төгрөг, Эмээлт эко аж үйлдвэрийн парк ОНӨААТҮГ 9.5 сая төгрөг, Улаанбаатар хотын хөгжлийн корпорац ХК 8.1 сая төгрөг байна.




1.11 Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолоор орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан аймгийн Тамгын газрын бүтэц, орон тоог 41-57 байхаар баталсан.

1.12 Гэвч зарим аймгийн Засаг дарга нар орон тооны хязгаарт зөвхөн улс төрийн болон төрийн жинхэнэ албан хаагчийг хамааруулж, төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тоог дээрх тогтоолд хамааруулахгүй шийдвэрлэж байна. Энэ нь төрийн албан хаагчийн тоог нэмэгдүүлж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” зарчимд нийцэхгүй байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт 6-д харуулав)*

1.13 Засгийн газрын 2025 оны “*Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг шинэчлэн тогтоох тухай*” 37 дугаар тогтоолоор Тамгын газрын бүтэц, орон тоог батлахдаа аймаг, нийслэлийн ЗДТГ-т ажиллаж буй төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тоог дээд хязгаарт хамааруулах эсэх нь тодорхойгүй хэвээр байна.

1.14 Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1344 дүгээр тушаалаар “Орон сууц, ашиглалтын хэлтэс”-ийн 30 орон тоог шинээр баталсан боловч үйл ажиллагаа явуулаагүй, Говьсүмбэр аймаг шинэ цэцэрлэгийн байр ашиглалтад ороогүй байхад 68 орон тоо баталсан зэрэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6[8]-д заасантай нийцэхгүй байна.

1.15 Иймд аймаг, нийслэлийн ЗДТГ-т ажиллаж буй төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тооны дээд хязгаарыг хэрэгцээ, шаардлага, судалгаа тооцоонд үндэслэн тогтоох шаардлагатай байна.

1.16 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “*төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно*” гэж заасны дагуу Засгийн газар болон Баянхонгор, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Ховд аймгуудын бүх шатны ИТХ-ууд цалин хөлсний нийтлэг жишгийг батлаагүйгээс ТБОНӨ-т хуулийн этгээдүүд харилцан адилгүй батлагдсан цалингийн сүлжээг тус тусдаа мөрдөн ажиллаж байна.

1.17 Аймгуудын Засаг даргын нөөц хөрөнгө болон төсвөөс 1,239.5 сая төгрөгийн хуулиар зөвшөөрөөгүй бусад зардал, дэмжлэг, урамшууллыг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1[9], 16 дугаар зүйлийн 16.5.5[10], Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4

[8] байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.
[9] төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.
[10] батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

дүгээр зүйлийн 4.1.6[11], 4.1.9[12], 11 дүгээр зүйлийн 11.1[13], 12 дугаар зүйлийн 12.1.4[14] дэх заалт, мөн Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн шагнал олгох журам"-ын 3.3[15]-т заасныг зөрчсөн байна. Үүнд:

**Ховд:**

- Аймгийн ИТХ нь төлөөлөгч нарыг гадаад улсад туршлага судлахад зориулж 231.0 сая төгрөг, Чандмань сумын ЗДТГ байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ажилд 3.0 сая төгрөгийг зарцуулсан;

**Сүхбаатар:**

- Сүхбаатар аймгийн зарим сумын ИТХ-ын ажлын алба иргэн, хуулийн этгээдээс ирсэн хүсэлтийг шийдвэрлэж 2023-2024 онд буцалтгүй тусламж, дэмжлэг, шагнал урамшууллалд Баруун-Урт сум 56.6 сая төгрөг, Асгат сум 2.1 сая төгрөг, Түвшинширээ сум 1.5 сая төгрөг, Түмэнцогт сум 1.6 сая төгрөг, Уулбаян сум 4.0 сая төгрөг, Эрдэнэцагаан сум 5.9 сая төгрөг, нийт 71.7 сая төгрөгийг зарцуулсан;
- Баруун-Урт сумын ИТХ-ын төлөөлөгчдөд 2023-2024 оны үйл ажиллагааны зардлаас тойргийн зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн халамжийн үйл ажиллагаанд 62.0 сая төгрөг, мөн Баяндэлгэр, Мөнххаан, Түвшинширээ, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан сумын 2023-2024 оны үйл ажиллагааны зардал 121.8 сая төгрөгийг төлөөлөгчийн хувийн дансанд шилжүүлсэн, Асгат, Эрдэнэцагаан сумын ИТХ-ын даргын шийдвэрээр төлөөлөгчдийн урамшууллалд 52.5 сая төгрөг, нийт 236.3 сая төгрөгийг зарцуулсан;
- Аймгийн ЗДТГ, Засаг даргын нөөц сангаас УИХ, Засгийн газрын гишүүд, дагалдан явсан ажлын хэсгийн багийн орон нутагт зохион байгуулсан уулзалт, зөвлөгөөн, хүлээн авалтын хоол, зочид буудлын хөлс зэрэгт 204.6 сая төгрөгийг зарцуулсан;
- Баруун-Урт сумын Засаг дарга нь хуульд тусгагдаагүй багийн хэсгийн ахлагч гэх орон тоонд 64 иргэнийг томилон ажиллуулж, төсвөөс шагнал, урамшууллалд 78.2 сая төгрөг, тус сумын 9 дүгээр багийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд төсвөөс 19.0 сая төгрөг, 2023-2024 онд шийдвэр гаргаж тэтгэмжийг давхардуулан 4.0 сая төгрөг, нийт 101.2 сая төгрөгийг зарцуулсан;

**Дорноговь**:

- Аймгийн Татварын газрын даргын 2024 оны А/33 дугаар тушаалаар 41 албан хаагчид цалингийн зардлаас 69.8 сая төгрөгийн урамшуулал олгосон;

**Баянхонгор:**

- Засаг даргын нөөц сангаас 2024 онд улс төрийн албан хаагчдыг ажлаас чөлөөлөгдөхөд дэмжлэг үзүүлсэн, байгууллагын төсвөөс гадаад оронд туршлага судалсан, албан хаагчдад тэтгэмж олгосон, биеийн тамир уралдаан тэмцээний шагнал, урамшууллалд нийт 40.6 сая төгрөгийг зарцуулсан;

**Говьсүмбэр**:

- Нэр бүхий 3 байгууллага төрийн одон медалиар шагнагдсан 5 албан хаагчийн шагналд 12.5 сая төгрөг, Шивээговь сумын ЭМТ-ийн даргын 2023 оны Б/21 дүгээр тушаалаар караоке тэмцээнд амжилттай оролцсон 5 ажилтанд үндсэн цалингийн 20.0 хувиар тооцож цалин сангаас урамшууллалд 0.8 сая төгрөг, нийт 13.3 сая төгрөгийг олгосон;

**Завхан**:

- Их-Уул, Нөмрөг сумын ИТХ, Нөмрөг, Тосонцэнгэл сумдын ЗДТГ нь 2024 онд батлагдсан орон тооноос дутуу ажилласан 4 орон тооны цалингийн зарцуулаагүй үлдэгдлийн 30.3 сая төгрөгийг ажилчдын урамшуулал, бусад зардалд зарцуулсан;

---

[11] сахилга баттай байх.
[12] хариуцлагатай байх.
[13] Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй.
[14] хуулиар зөвшөөрөөгүй бусад.
[15] Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна.

- Нийт 5 байгууллагаас тэтгэвэрт гарсан 15 албан хаагчдад 6.2 сая төгрөгийн тэтгэмж давхардуулан олгосон;

**Дархан-Уул:**

- Аймгийн Музей, Хонгор сумын Соёлын төвийн нягтлан бодогч нарт 2024 оны цалин, ээлжийн амралтын мөнгийг давхардуулан 1.9 сая төгрөг, Хонгор сумын 16 дугаар цэцэрлэгт туслах багшаар ажиллаж байгаад дотроо өөр ажилд шилжин томилогдсон ажилтанд 2024 оны 12, 2025 оны 1, 2 дугаар сарuудад ажиллаагүй хугацааны цалинд 5.1 сая төгрөгийг, биеийн тамирын багшийн албан тушаалд шинээр томилогдсон боловч ажиллаагүй 1 хүнд 2025 оны 1, 2 дугаар сард ажилласнаар тооцож цалинд 5.2 сая төгрөгийг тус тус олгосон байна.
- Улаанбаатар цахилгаан сүлжээ ТӨХК 2022-2024 онд хууль тогтоомжийг зөрчиж мөнгөн шагнал, урамшуулалд 252.5 сая төгрөг олгож, 2022 онд 1,031.7 сая төгрөг, 2023 онд 1,123.5 сая төгрөг, 2024 онд 1,206.0 сая төгрөг нийт 3,361.2 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан боловч тухай бүр нь жолоочийн замын хуудасны тооцоог бодоогүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй;

**Өмнөговь:**

- Аймгийн ИТХ, Ханбогд, Сэврэй сумын Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ, Манлайнбадрах ОНӨААТҮГ, Номдизель ОНӨААТҮГ зэрэг байгууллага дэмжлэг урамшууллын зардалд нийт 37.4 сая төгрөгийг зарцуулсан;
- Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ 2024 онд ажлын үр дүнг үнэлэх шалгуурт нийцээгүй албан хаагчдад сар бүр 10.0-20.0 хувийн урамшуулалд 29.9 сая төгрөгийг олгосон;

1.18 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “*Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно.*” гэж 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1.19 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 болон 15 дугаар зүйлд хэмнэлтийн бусад арга хэмжээ, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын төсвөөс санхүүжүүлэхийг хориглосон үйл ажиллагааны талаар тухайлан заасан хэдий ч холбогдох зөрчлийн тоо буурахгүй байна.

1.20 Тухайлбал, 2023-2024 онд дараах төсвийн байгууллагууд нь танилцуулга, үйл ажиллагааны мэдээлэл, кино контент, телевизийн нэвтрүүлэг, сумын ойн арга хэмжээний контент бүтээх болон бэлэг дурсгалын зүйл худалдан авахад, нийт 980.7 сая төгрөгийг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3[16], 15.1.4[17], 15.1.5[18]-д заасныг зөрчсөн байна.

**Архангай:**

- Архангай аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 2024 оны сургалтын зардлын зарцуулаагүй үлдэгдэл 195.1 сая төгрөгийг нэр бүхий 2 төрийн бус байгууллага руу шилжүүлж, аймгийн Боловсролын газрын холбогдох албан тушаалтнууд 2025 онд сургалт зохион байгуулсан байна;

**Өмнөговь:**

- Аймаг, сумдын 19 байгууллага 2024 онд бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 303.5 сая төгрөг, 4 байгууллага контент бэлтгэхэд 196.5 сая төгрөг, нийт 500.0 сая төгрөгийг зарцуулсан;

**Ховд:**

- ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд аймгийн контент хийлгэх 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг худалдан авах ажиллагаа зарлахгүй шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн, Чандмань

---

[16] хууль тогтоомжид заасанаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох.

[17] Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх.

[18] төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах.

сумын 100 жилийн ойтой холбоотой аялал жуулчлалыг татах бичлэг хийлгэхэд 40.0 сая төгрөг, нийт 160.0 сая төгрөгийг зарцуулсан;

**Нийслэл:**

- ЧД-ийн ЗДТГ-аас ахмадын хорооны дарга нарт олгосон 2 удаагийн дэмжлэгт 60.8 сая төгрөг, тус ахмадын хороогоор дамжуулан ахмад настнуудын анхан шатны эрүүл мэндийн үзлэгийн төлбөрт 96.0 сая төгрөг, Нийслэлийн ИТХ дотоод томилолтын зардлаас бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 1.2 сая төгрөг, нийт 158.0 сая төгрөгийг зарцуулсан;

**Баянхонгор**:

- ИТХ-ын төлөөлөгч нарт 2024 онд ээлжит сонгууль болсонтой холбогдуулан хүндэтгэл үзүүлэхэд бэлэг дурсгалын зүйл, мөнгөн аяга худалдан авахад 54.4 сая төгрөг, сумын 100 жил, цагаан сар болон ахмадын баяраар бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 11.8 сая төгрөг, нийт 66.4 сая төгрөгийг зарцуулсан;

**Төв:**

- Баян-Өнжүүл, Мөнгөнморьт, Зуунмод сумдын ЗДТГ, Баянцагаан сумын ИТХ, аймгийн ГХБХБГ-ууд бэлэг дурсгалын зүйл бэлтгэхэд 28.2 сая төгрөг, Аргалант, Сэргэлэн сумдын ЗДТГ, аймгийн Худалдан авах ажиллагааны газар байгууллагын танилцуулга, кино контент, телевизийн нэвтрүүлэг зэрэгт 14.0 сая төгрөг, нийт 42.2 сая төгрөгийг зарцуулсан;

**Дорноговь:**

- Аймгийн Засаг даргын 2024 оны А/126 дугаар захирамжаар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчлэл, үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх 4 төрлийн контент хийлгэхэд 19.7 сая төгрөг, Замын-Үүд сумын ЗДТГ сумын 30 жилийн ойн арга хэмжээний хүрээнд гэрээний дагуу баримтат контент хийлгэхэд 10.0 сая төгрөг, нийт 29.7 сая төгрөгийг зарцуулсан;

**Хөвсгөл:**

- Нэр бүхий 27 байгууллага төсвөөс бэлэг дурсгалын зүйлс бэлтгэхэд 14.2 сая төгрөгийг зарцуулсан;

**Баян-Өлгий**:

- Хүнс, хөдөө аж ахуйн газар шинэ жилийн баяраар ажилтан, албан хаагчдад 2.6 сая төгрөгийн гарын бэлэг олгосон, Өлгий сумын ИТХ-аас 21 аймгийн ИТХ-ын ажлын албаны чуулга уулзалт, бэлэг дурсгалд 3.0 сая төгрөг, ойн баяр, бусад арга хэмжээнд зориулан тэмдэг, өргөмжлөлийн үнэд 4.6 сая төгрөг, нийт 10.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Сүхбаатар**:

- Сүхбаатар аймгийн ЗДТГ нь 22.5 сая төгрөгийг 2 иргэний дансанд шилжүүлсэн боловч худалдан авалтыг хийгээгүй, харилцагчаас авах авлага үүсгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 , 41.2.3 , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 , 20 дугаар зүйлийн 20.2.4 , 20.2.5 -д заасныг тус тус зөрчсөн байна.

1.21 Аудитын түүвэрт хамрагдсан ТБОНӨ-т хуулийн этгээдүүд хуулиар зөвшөөрөөгүй бусад зардал, дэмжлэг, урамшууллыг олгож Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1[19], 16 дугаар зүйлийн 16.5.5[20], Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6[21], 4.1.9[22], 11 дүгээр зүйлийн 11.1[23], 12 дугаар зүйлийн 12.1.4[24], 15 дугаар зүйлийн 15.1.3[25] 15.1.6[26], 15.1.7[27]-д тус тус заасныг зөрчсөн байна. Үүнд:

- ТБОНӨ-т зарим хуулийн этгээдүүд Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажилд дэмжлэг үзүүлэхээр орон нутагт ажиллуулах авто машины

---

[19] төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.
[20] батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.
[21] сахилга баттай байх.
[22] хариуцлагатай байх.
[23] Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй.
[24] хуулиар зөвшөөрөөгүй бусад.
[25] хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно.
[26] нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх.
[27] байгууллагын төсвөөр соргуурулах ундаа худалдан авах.

түрээсийн төлбөр, томилолтын зардал болон бусад зардалд нийт 1,596.7 сая төгрөгийн төлөвлөгөөгүй зардлыг зарцуулсан; *(Дэлгэрэнгүйг хавсралт 7-д үзүүлэв)*

- Эрдэнэс Алт ресурс ХХК нь 2022 онд түрээсийн гэрээгээр конторын зориулалттай 478 м.кв талбайг түрээсэлсэн бөгөөд 2025 оны 3 дугаар сараас 1м.кв талбайн үнийг 80,000 төгрөг болгосон, мөн 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс шинээр 85.1 м.кв талбайг нэмж 90,300 төгрөгөөр тус тус түрээсэлж ТӨБЗГ-ын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 139 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг зөрчсөн;
- Булган Мээж ОНӨХХК нь Цемент шохой ТӨХК-аас 1000 шуудай буюу 50 тн цементийг худалдан авч, жилийн эцсийн байдлаар 559 шуудай буюу 27.9 тн цементийн үлдэгдэлтэй, хэрэгцээ шаардлага нь тодорхойгүй материал их хэмжээгээр нөөцөлсөн;
- Дорноговь АЗЗА ТӨХК-ийн захирлын 2024 оны А/47 дугаар тушаалаар байгууллагын шинэ жилийн баярын үйл ажиллагаанд зориулж 40 ширхэг оргилуун дарс худалдан авахад 2.0 сая төгрөг зарцуулсан байна.
- Говьсүмбэр аймгийн “Талын Илч”, “Ус-Ду” ОНӨААТҮГ-ын албан хэрэгцээнд зориулан 224.7 сая төгрөгийн 2 суудлын автомашин худалдан авч, захирлын албан хэрэгцээнд ашиглаж байна.
- Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК хууль тогтоомжид нийцээгүй 96.3 сая төгрөгийн мөнгөн шагнал, урамшуулал олгосон.
- Монголын цахилгаан холбоо ХК спортын тэмцээн уралдааны зардалд 12.7 сая төгрөг зарцуулсан;
- Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн ТУЗ-өөс гүйцэтгэх захиралтай 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан 2017/01 дугаартай "Хөлсөөр ажиллах гэрээ"-нд ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 36 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан сунгаж, Хөлсөөр ажиллах гэрээтэй ажилтанд 2022, 2023 онд нийт 38.9 сая төгрөгийг урамшуулалд олгосон;
- 

1.22 Орон нутгийн ТЕЗ-ийн харьяа төсвийн байгууллагаас 2024 онд нийт 598.2 сая төгрөгийн хувцас, удаан хадгалах шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр бэлтгэн нөөцөлж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 15 дугаар зүйлийн 15.1.6[28], 15.1.7[29]-д заасныг зөрчсөн байна.Үүнд:

**Завхан:**

- Эрүүл мэндийн салбарын 1 байгууллага 12.1 сая төгрөгийн эмийг нөөцөлсөн, 6 байгууллага хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийн 92.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй;
- Нэгдсэн эмнэлгийн эмийн үлдэгдэл E-Health программын үлдэгдлээс 129.7 сая төгрөгийн зөрүүтэй;
- Боловсролын салбарын 12 байгууллагын 16.5 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдлийн хугацаа дууссан, 9 байгууллага 51.2 сая төгрөгийн хүнсний материалыг шаардлагатай хэмжээнээс илүү нөөцөлсөн, 3 байгууллага хүнсний материалыг зах зээлийн үнээс 10.4 сая төгрөгөөр илүү үнэтэй бэлтгэсэн зэрэг нийт 78.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн;
- Алдархаан, Дөрвөлжин, Отгон, Сонгино, Тэс, Улиастай сумын ЗДТГ төсвөөс хүндэтгэлийн арга хэмжээ, баяр ёслол, уралдаан тэмцээнд 85.9 сая төгрөгийг зарцуулсан;

**Хөвсгөл:**

- Нэр бүхий 38 байгууллага төсвөөс 29.3 сая төгрөгийн согтууруулах ундааны зүйлс, 54.4 сая төгрөгийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагагүй бараа материалыг, нийт 83.7 сая төгрөгөөр худалдан авсан;
- Сумдын Эрүүл мэндийн төвийн бараа материалын үлдэгдэлд жилийн турш хөдөлгөөн гараагүй, бүртгэлд тусгасан 26.0 сая төгрөгийн хугацаа дууссан эмийн үлдэгдэлтэй;
- Ханх сумын ЭМТ нь албан хаагчдад биеийн тамирын хувцас худалдан авахад 1.3 сая төгрөг, Мөрөн сумын 6 дугаар цэцэрлэг нь ижил төрлийн хувцас, хэрэглэл худалдан авахад 2.8 сая төгрөг, Байгаль орчны газар биеийн тамирын өмсгөл бэлтгэхэд 1.1 сая төгрөг, нийт 5.2 сая төгрөгийг зарцуулсан;

**Нийслэл:**

[28] нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх.
[29] байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.

- Нийслэлийн ИТХ 36.4 сая төгрөгийн ном, эмхэтгэлийг, СХД-ийн ИТХ 17.6 сая төгрөгөөр хүнсний болон бусад материалыг, нийт 54.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч нөөцөлсөн;

**Баянхонгор:**

- 2024 онд Шинэжинст сумын ЗДТГ, Галуут сумын соёлын төв, Эрүүл мэндийн төв, Баян-Овоо сумын Эрүүл мэндийн төв нь төсвийн хөрөнгөөр нийт 14.0 сая төгрөгийн биеийн тамирын хувцас болон гадуур хүрэм худалдан авсан;

**Дорнод:**

- Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2024 оны эцэст нэмэлт санхүүжилтийн данснаас ажилтнуудын ажлын костюм захиалгаар хийлгэхэд 8.8 сая төгрөгийг зарцуулсан;

**Дорноговь:**

- Аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны А/59 дүгээр тушаалаар Зүүн болон говийн бүсийн аймгуудын ЗДТГ-ын албан хаагчдад нэгдсэн спортын арга хэмжээний 50 ширхэг тэмцээний хувцас худалдан авахад 3.6 сая төгрөг, Хатанбулаг сумын ЭМТ 22 ширхэг хатгамалтай цамц худалдан авахад 2.8 сая төгрөг, нийт 6.4 сая төгрөгийг зарцуулсан;
- Сайншанд сумын ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгөөс харшийн шинэ жилд зориулж 20 ширхэг оргилуун дарсыг 0.2 сая төгрөг, нийт 2.2 сая төгрөгийг зарцуулсан.

1.23 Мөн зарим аймаг, нийслэлийн ТЕЗ-ийн харьяа төсвийн байгууллага болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь 2023-2024 онд үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй арга хэмжээний зардалд 730.3 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6[30], 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасантай нийцэхгүй байна. Тухайлбал:

**Нийслэл:**

- 2024 онд СХД-ийн ЗДТГ архивын сургалтын заавар журмын эмхэтгэл, олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах сургалтад зориулж гарын авлага хэвлүүлэхэд 27.5 сая төгрөг, СХД-ийн ИТХ хэвлэл захиалгын төлбөрт 26.5 сая төгрөг, ХУД-ийн ЗДТГ хэвлэл захиалгын төлбөрт 4.5 сая төгрөг, Нийслэлийн ИТХ хэвлэл захиалгын төлбөрт 3.1 сая төгрөг, ХУД-ийн ЗДТГ тахилгын ёслол хийх, амны хаалт их хэмжээгээр худалдан авахад 50.4 сая төгрөг, БНД-ийн ИТХ чадавхжуулах арга хэмжээний нийтлэг жишгийг мөрдөж ажиллаагүй 31.2 сая төгрөг, нийт 143.2 сая төгрөгийг зарцуулсан;

**Төв:**

- Аймгийн ЗДТГ-ын төсвөөс хоолны зардалд 145.8 сая төгрөг, шинэ жилийн арга хэмжээний зардалд 73.1 сая төгрөг, нийт 218.9 сая төгрөгийг зарцуулсан;
- Алтанбулаг, Баян, Баянчандмань, Заамар, Зуунмод, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Угтаал сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Аймгийн ИТХ-ын зохион байгуулалт, олон нийттэй харилцах хэлтсийн дарга, ажлын албаны мэргэжилтэн, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга нар Турк улс руу туршлага солилцох хөтөлбөрийн зардалд, төсөвт батлагдаагүй 71.8 сая төгрөгийг зарцуулсан;

**Дархан-Уул:**

- Дархан-уул аймгийн Хонгор сумын Засаг дарга, Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Засаг дарга нар Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК-тай “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх хүрээнд сумтай хамтран ажиллах” гэрээний дагуу олгосон хандиваас 2023-2024 онд нийт 214.0 сая төгрөгийг үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй, тэмцээн уралдаан зохион байгуулах, ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, өвөлжилтийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх зэрэгт зарцуулсан;

**Сүхбаатар:**

- Аймгийн ЗДТГ болон харьяа байгууллагуудын албан хаагчдыг 2023–2024 онд зүүн бүсийн Тамгын газрын спортын арга хэмжээнд оролцуулахтай холбоотой зардалд нийт 46.2 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан;

**Говьсүмбэр:**

[30] үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх.

- Эрүүл мэндийн салбарын 1 байгууллага ажилчдын урмыг сэргээх, тэмдэглэлт өдрүүдийг нэгтгэн тэмдэглэхээр хүчин төгөлдөр бус хамтын гэрээнд заасныг үндэслэн албан хаагчдыг гадаад улсад аялах зардалд 14.8 сая төгрөг, боловсролын салбарын нэр бүхий 5 байгууллага сургалтын хоолны төлбөрт 2.7 сая төгрөг, БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан журамд заасан нөхөн хангалтын зардлаас зориулалтын бус урсгал зардалд 2.7 сая төгрөг, нийт 20.2 сая төгрөгийг зарцуулсан;

**Баян-Өлгий:**

- Өлгий сумын ИТХ нь төлөөлөгчдийн монтажны үнэд 6.7 сая төгрөг, шинэ жилийн арга хэмжээ болон Өлгий-Улаанбаатар-Эрдэнэт чиглэлийн хоёр талын унааны зардалд 7.0 сая төгрөг, Шүүх шинжилгээний хэлтсийн барилгын 3 дугаар давхарт амьдардаг 2 албан хаагчийн байрны халаалт, цэвэр бохир усны төлбөрт төсвөөс 1.4 сая төгрөг, Сагсай сумын Даян багийн ерөнхий боловсролын сургууль, Булган, Сагсай сумдын Соёлын төвийн албан хаагчдад гар утасны нэгжийн төлбөрт 0.9 сая төгрөг, нийт 16.0 сая төгрөгийг зарцуулсан.

1.24 Дараах ТБОНӨ-т хуулийн этгээдүүд байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй зарим төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн, охин болон хараат компанид олгосон санхүүжилт эргэн төлөгдөх эсэх тодорхойгүй өр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1[31], 6 дугаар зүйлийн 6.4.1[32], 6.4.8[33] 25 дугаар зүйлийн 25.10[34], Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6[35], 4.2.6[36], 15 дугаар зүйлийн 15.2.5[37]-д тус тус заасанд нийцээгүй, УИХ-ын 2024 оны 09 дүгээр тогтоолын 3[38]-т заасныг мөрдөж ажиллаагүй байна. Үүнд:

- Эрдэнэс Тавантолгой ХК нь:
  - Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлийг үндэслэн 2018-2024 онд "Таван толгой түлш ХХК-ийн шахмал түлш үйлдвэрлэх төслийг санхүүжүүлэх гэрээ"-г 19 удаа, нэмэлт гэрээг 10 удаа, нүүрсний гэрээг 3 удаа байгуулж, нийт 1,385,126.1 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй, хүүгүй олгосон;
  - Засгийн газрын 2022 оны 94 дүгээр тогтоолд заасны дагуу бүтээгдэхүүн урьдчилан борлуулах замаар "Газрын тос боловсруулах үйлдвэрийн газрын тос дамжуулах хоолойн байгууламж барихад шаардагдах хөрөнгө"-ийн санхүүжилтэд 2,115,544.9 тонн нүүрс буюу 633,236.3 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон;
  - Засгийн газрын 2021 оны 353 дугаар тогтоолын дагуу Богдхан төмөр замын төслийн санхүүжилтэд 42,737.1 сая төгрөг мөн 257,783.15 тонн нүүрс буюу 88,181.4 сая төгрөг, нийт 130,918.5 сая төгрөгийг 2022 оны 8-11 сард олгосон боловч төслийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсон;
- Мөн Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ радио, телевизийн өргөн нэвтрүүлэг дамжуулахад зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, гэрэл цахилгааны үнийн өсөлтийг тооцож, төсөвлөн жил бүр дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн ч тодорхойгүй шалтгаанаар хасагдаж, хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр өр төлбөр өсөх тооцоо гарсан;
- Цемент шохой ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс тогтоосон 3,471.6 сая төгрөгийн ногдол ашгийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь ТӨБЗГ-ын 2024 оны "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны

---

[31] Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна.
[32] "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.
[33] төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.
[34] Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.
[35] сахилга баттай байх.
[36] үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх.
[37] хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж, өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх.
[38] Эрдэнэс Тавантолгой ХК, Тавантолгой ХК болон төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдээс цаашид төсвийн шинжтэй, компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээг авах.

ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай" 351 дүгээр тогтоолын 1-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг хавсралт ёсоор тогтоосугай" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

1.25 Төсөв захирагчид нь өр төлбөрийг барагдуулахаар жилийн төсөвтөө тусгаж, өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5[39]-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.26 Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тухайн жилийн төсвийг бодитой төлөвлөөгүйгээс тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй 2022 онд 251,826.8 сая төгрөг, 2023 онд 375,084.9 сая төгрөг, 2024 онд 342,379.4 сая төгрөг, нийт 969,291.1 сая төгрөгийг улсын төсөвт буцааж татан төвлөрүүлэх нөхцөл үүсгэсэн нь аливаа үйл ажиллагаа өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх зарчимд нийцэхгүй байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт 8-д үзүүлэв)*

***Улс, орон нутгийн төсвийн байгууллага, ТБОНӨ-т хуулийн этгээдүүд хуульд заасан хангамж, зарим үйл ажиллагааны хязгаарлалттай холбоотой зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчил буурахгүй байна.***

[39] хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж.

## БҮЛЭГ 2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТТАЙ ДАВХАРДАЖ БАЙГААГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЖ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

**Тухайн тайлант онд хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хуульд заасан хугацаа хангалттай байсан ч захиалагчийн зарим буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хэрэгжилтийн зохион байгуулалт хангалтгүй байна**

2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "*батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах*" гэж заасныг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.

2.2 Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд шинээр хэрэгжүүлэх 110 төсөл, арга хэмжээг батлалснаас худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан 80, тендер шалгаруулалтын үнэлгээ хийгдэж байгаа 18, амжилтгүй болсон 8, огт тендер шалгаруулалт зарлаагүй 3, нууцад хамаарах нэг төсөл, арга хэмжээ байна.




2.3 Үүнээс 2025 онд хуульд заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй, зарлаагүй 24 багц бүхий 11 төсөл, арга хэмжээний 22,948.8 сая төгрөгийн санхүүжилтийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2[40]-т заасны дагуу төсвийн хэмнэлтэд тооцохоор байна.

2.4 Засгийн газрын тогтоолд үндэслэн он дамжин хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт нийт 1,787,683.4 сая төгрөгийг 2019-2024 онд 23 ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулснаас, 2025 оны 5 дугаар сарын 15-ны байдлаар олгогдоогүй 726,141.3 сая төгрөг харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

**Хүснэгт 1.** УТХО-ын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан үлдэгдэл /*сая төгрөг*/

| Д/д | Засгийн газрын тогтоол | Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн | Чөлөөлсөн дүн | Буцаан төвлөрүүлсэн дүн | Үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2019 оны 430-р тогтоол | 160,893.8 | 141,999.1 | 17,313.1 | 1,581.5 |
| 2 | 2020 оны 253-р тогтоол | 50,258.8 | 48,256.5 | 1,514.1 | 488.3 |
| 3 | 2021 оны 397-р тогтоол | 378,380.8 | 323,488.7 | 48,785.8 | 6,106.3 |
| 4 | 2022 оны 495-р тогтоол | 77,681.8 | 57,058.9 | 9,976.5 | 10,646.4 |
| 5 | 2023 оны 456-р тогтоол | 428,885.3 | 314,081.6 | 16,171.6 | 98,632.1 |
| 6 | 2024 оны 249-р тогтоол | 691,582.8 | 82,765.4 | 130.7 | 608,686.8 |
| | **Нийт** | **1,787,683.4** | **967,650.2** | **93,891.8** | **726,141.3** |

*Эх сурвалж: Сангийн яам*

2.5 Барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлээс гурваас дээш жилийн насжилттай, он дамжсан зарим төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт хангалтгүй, дутуу гүйцэтгэлтэй, хугацаа дууссан нийт 1,784.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг улсын төсөвт буцаан

[40] энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох.

төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 7.7[41], 43.5[42], 45.2[43], 45.2.2[44]-т тус тус заасныг зөрчсөн, Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын 1.2[45], 2020 оны 253 дугаар тогтоолын 2[46], 2021 оны 397 дугаар тогтоолын 1.3[47], 2022 оны 495 дугаар тогтоолын 1.2[48], 2023 оны 456 дугаар тогтоолын 1.3[49]-т заасныг хэрэгжүүлээгүй зөрчилд аудитаар төлбөрийн акт тогтоосон.

2.6 Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн IV.4.4.1 дугаарт "*Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/*" хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг баталсан боловч эрх бүхий албан тушаалтнууд Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолын 1.3-т заасныг зөрчин худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, гэрээгүй байхад барьцааны өглөгийн дансанд хөрөнгө оруулалтын нийт төсөвт өртөг 60,000.0 сая төгрөгийг байршуулсан байна. 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 49,240.5 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг хэмнэлтэд тооцохоор байна.

2.7 Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 373,373.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дараах 11 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан боловч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний мэдээллийг Сангийн яамны pimis.publicinvestment.gov.mn сайтад байршуулаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн ил тод байх зарчмыг алдагдуулж, хяналт сулрах эрсдэл үүсгэхээр байна.

**Хүснэгт 2.** Гэрээний мэдээлэл байршуулаагүй төсөл, арга хэмжээний судалгаа /сая төгрөг/

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр | Төсөвт өртөг |
|---|---|---|
| Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга | | |
| | 1. Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Өндөр-Улаан сум/ | 2,453.9 |
| Боловсролын сайд | | |
| | 1. Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 34 дүгээр хороо/ | 15,795.2 |
| | 2. Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо/ | 3,473.8 |
| Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | | |
| | 1. Иргэд, хүүхэд, залуучууд, ахмад настанд зориулсан хөгжлийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хороо/ | 3,000.0 |
| | 2. Тусгай хэрэгцээт иргэдийн тоног төхөөрөмж /Төв/ | 150.0 |
| Зам, тээврийн сайд | | |

[41] Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.
[42] Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй.
[43] Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ.
[44] төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл.
[45] Банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны дотор Сангийн яаманд хүргүүлж, тус яамны зөвшөөрлөөр чөлөөлөх.
[46] Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төслүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг ТЕЗ нарт даалгасугай.
[47] Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.
[48] Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан бодит гүйцэтгэлийг хянан санхүүжүүлэх.
[49] Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх.

| | | |
|---|---|---|
| | 3 Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 63.5 км /Ховд, Мөнххайрхан сум/ | 70,105.1 |
| | 4 Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152.5 км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/ | 263,595.4 |
| Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд | | |
| | 1. Нийтийн биеийн тамирын төвийн барилга /Архангай, Эрдэнэбулган сум, 1, 2, 3, 5, 7 дугаар баг/ | 4,000.0 |
| Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд | | |
| | 1. Сумын төвийн газар доогуурх дулаан, цэвэр усны төв шугам, худаг /Сэлэнгэ, Орхонтуул сум/ | 1,800.0 |
| | 2. Сумын төвийн цэвэр, бохир ус дулааны шугам сүлжээ /Ховд, Үенч сум/ | 3,000.0 |
| | 3. “Сервис центр-2” дэд бүтцийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг 14, 16, 18 дугаар хороо/ | 6,000.0 |
| | **НИЙТ 11 төсөл, арга хэмжээ** | **373,373.4** |

**Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд хамааралгүй, хуулиар хориглосон төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна.**

2.8 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг хориглосон тохижилтын болон яамны чиг үүрэгт хамааралгүй нийт 7,800.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээг тусган баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6,[50] 13 дугаар зүйлийн 13.4.1[51]-д нийцэхгүй байна. Үүнд:

- Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "3x3" сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл;
- Ховд аймагт 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "3x3" сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл;
- Завхан аймагт 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон байгууламж бүхий орчны тохижилт”;
- Ховд, Жаргалант сумд 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон байгууламж бүхий орчны тохижилт”;
- Ховд аймгийн Мөнххайрхан, Буянт, Мөст, Ховд, Эрдэнэбүрэн сумдад 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон байгууламж бүхий орчны тохижилт”;
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумд 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Талын наран цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж”;
- Булган аймгийн Дашинчилэн, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Баян-Агт, Булган сумдад 1,700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхдийн тоглоомын талбай”;

2.9 Нийслэлд орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийн 2023 оны 103.3 сая төгрөг, 2024 оны 22,262.3 сая төгрөг, нийт 22,365.6 сая төгрөгийг зарцуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3[52]-т заасныг зөрчсөн байна.

---

[50] 4.2.6.үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх.
[51] 13.4.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: ...13.4.1. орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт”.
[52] хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх.

2.10 Мөн дараах аймгуудын ТЕЗ нь ОНХС, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 53,712.4 сая төгрөгийн санхүүжилтээр хөшөө, дурсгал, угтах хаалга барьсан, хувийн өмчид шилжих, орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн, мөн зураг төсөвгүй ажлыг төлөвлөн баталж, гүйцэтгүүлсэн зэрэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4[53], 13.1.5[54], 13.3.1[55], 13.4.1[56], Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3[57], 18 дугаар зүйлийн 18.1[58], 41 дүгээр зүйлийн 41.1.1[59]-д заасныг тус тус зөрчсөн байна. Үүнд:

**Завхан:**

- Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгасан нийт 3,235.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл арга хэмжээг ТЭЗҮ, зураг төсөвгүй баталсан, мөн 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ нь орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай, Дөрвөлжин, Баянтэс сумын Засаг дарга нар 2023, 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 388.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй байхад гэрээ байгуулах шийдвэр гаргасан, нийт 3,654.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн;

**Сэлэнгэ:**

- Аймаг, сумдын ОНХС болон ОНХО-ын төлөвлөгөөнд 2023-2024 онд 1,852.4 сая төгрөгийн төсвийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй, нийтийн эзэмшлийн орон сууцны барилгын болон дээврийн засварын 13 төсөл, арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлсэн;

**Ховд:**

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд Зэрэг сумын гудамж талбайн тохижилт хийх ажилд 299.9 сая төгрөг, Манхан сумын гудамж, талбайг тохижуулах ажилд 200.0 сая төгрөг, Цэцэг сумын авто зогсоол болон тохижилтын ажилд 199.8 сая төгрөг, Буянт сум нийтийн эзэмшлийн талбай тохижуулах ажилд 149.8 сая төгрөг, Чандмань сумын гэрэлт цамхаг болон гудамжны тохижилт, гэрэлтүүлэг хийх ажилд 79.8 сая төгрөг, Жаргалант сумын Жаргалан багийн тоглоомын талбай тохижуулахад 49.2 сая төгрөг, нийт 978.6 сая төгрөгийг зарцуулсан;
- ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд Цэцэг сум угтах хаалга хийлгэхэд 40.0 сая төгрөг, Үенч сум 5 хошуу малын хөшөө хийлгэх ажилд 20.0 сая төгрөг, Ховд сум гэрэлт хөшөө барихад 5.0 сая төгрөг, Үенч сум Амарсанаагийн цэнгэлдэх хүрээлэнд хөшөө барихад 14.3 сая төгрөг, нийт 79.3 сая төгрөгийг зарцуулсан;
- ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд Үенч сум 5 хошуу малын хөшөө барихад 30.0 сая, Буянт сум үдэлтийн талбайн засварт 12.9 сая төгрөг, Мянгад сум Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнд хөшөө барихад 9.3 сая төгрөг, нийт 52.2 сая төгрөгийг зарцуулсан;

**Увс:**

- Улаангом сум нь 2023 онд “Ухаалаг тоолуур нэвтрүүлэх ажил”-ын 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй төсөл, арга хэмжээг баталж, санхүүжүүлсэн;

**Булган**:

- Аймаг, сумдын 2022 оны ОНХО-ын төлөвлөгөөнд орон нутгийн өмчлөлд бүртгэх боломжгүй, нийтийн эзэмшлийн орон сууцны дээвэр, фасадын засварын 282.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлсэн;

**Баян-Өлгий:**

[53] төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх.
[54] хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх.
[55] хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах.
[56] орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалд, гэрэлтүүлэг, тохижилт
[57] Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хуваах худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.
[58] Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана.
[59] энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан.

- Өлгий сумын ЗДТГ нь 2024 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулаагүй, тендер сонгон шалгаруулалтгүй 43.0 сая төгрөгийн шатахуун болон 57.7 сая төгрөгийн хөрөнгийг, Цахилгаан шугам сүлжээний газар 60.4 сая төгрөгийн шатахууныг, Аймгийн ИТХ 25.3 сая төгрөгийн шатахууныг, Аймгийн ЗДТГ 20.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг, нийт 207.1 сая төгрөгийн хөрөнгийг тус тус гэрээ шууд байгуулан худалдан авсан;

**Орхон:**

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хувийн хэвшилд ашиглах, ашиг олох зорилготой 392.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, 170.6 сая төгрөгийг зарцуулсан;
- Орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3,583.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зураг төсөвгүй "Эрдэнэтэд үйлдвэрлэв" барилга барих төсөл арга хэмжээнд 2,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, баталсан;

**Өвөрхангай:**

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд эрх шилжүүлсэн нийт 33 төсөл, арга хэмжээнээс 43,402.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 19 төсөл, арга хэмжээг зураг төсөвгүй баталж, дараа нь зураг төсөв боловсруулах, магадлал хийх ажлыг зохион байгуулсан;

**Хэнтий:**

- Аймгийн ИТХ-ын 2024 оны 02 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан 36 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажаагүй, зураг, төсөвгүй;

**Сэлэнгэ:**

- Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 180 дугаар тогтоолоор 10 төсөл арга хэмжээний ХАА-ын үр дүнд бий болсон 115.2 сая төгрөгийн хэмнэлтийг шинээр 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан.
- Ерөө сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 142 дугаар тогтоолоор 18 төсөл арга хэмжээний ХАА-ын үр дүнд бий болсон 117.3 сая төгрөгийн хэмнэлтийг шинээр 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

2.11 Нийслэлийн төсвийн 2023-2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэл-нийцлийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4[60], 13.3.2[61], 13.3.3[62], 13.4.1[63], 13.4.3[64], 13.5[65]-д заасныг зөрчсөн дараах зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Нийслэлийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 65,134.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 104 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн байхад гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан;
- Нийслэлийн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй 55,451.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 105 төсөл арга хэмжээ, 1,173,082.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй техник, эдийн засгийн үндэслэл хийгээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгоогүй 580 төсөл арга хэмжээ, нийт 1,228,534.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 685 төсөл арга хэмжээг тусгаж, баталсан;
- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх 1,510.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нийтийн зориулалтай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэлт (БЗД)", 1,315.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нийтийн зориулалтай орон сууцны цахилгаан шатны шинэчлэлт

[60] төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх.
[61] хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ.
[62] техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.
[63] орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт;
[64] орон нутгийн авто замын засвар хийх.
[65] Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

(БГД)", 1,091.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “81/1 дүгээр байрны гадна фасад засвар (Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Их тойруу);

- 2024 онд СБД-т хэрэгжих 2,403.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “3-р хороо, нийтийн зориулалттай орон сууцны фасад засвар”, БГД-т хэрэгжих 2,295.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Фасад засварын ажил Багц-4” ТАХ нь хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй;
- ХУД-т хэрэгжих 2,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн зориулалттай орон сууцны дулаалга фасад засвар /нисэхийн бүс/,
- ЧД-т хэрэгжих 2,600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хорооны цогцолбор барилга барих”;
- Төсвийн хөрөнгө оруулалтаар 12,570.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон байгууламж бүхий орчны тохижилт (Улаанбаатар, Баянгол дүүрэг)”, 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ногоон гудамж, дэд бүтэц (Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг)”, 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "3х3" сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/;
- Төсвийн хөрөнгө оруулалтаар 22,950.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Дүүргийн хатуу хучилттай авто зам, замын шинэчлэл, гүүрэн байгууламж (Улаанбаатар, Баянгол дүүрэг) Багц-1”, 4,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Авто зам авто зогсоол /Улаанбаатар, Багануур дүүрэг 1, 3 дугаар хороо/”, 3,800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Авто замын шинэчлэл (Улаанбаатар, Баянгол дүүрэг, 2, 3, 4, 17, 18, 19 дүгээр хороо)” төсөл арга хэмжээ;
- ЧД-т хэрэгжих 1,200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ерөнхий боловсролын сургуулиудын ариун цэврийн өрөөг засварлах, шинэчлэх ажил“, БЗД-т хэрэгжих 513.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажил”, БГД-т хэрэгжих 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил-1”, СБД-т хэрэгжих 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хөрөнгө оруулалт, засвар шинэчлэлтийн ажил”, ХУД-т хэрэгжих 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил”, СХД-т хэрэгжих 220.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил”-ыг зураг төсөвгүй баталсан;
- ХУД-т хэрэгжих 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлэг”, БЗД-т хэрэгжих 365.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Тохижилтын ажил”, 385.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Гэрэлтүүлгийн ажил”, НД-т хэрэгжих 274.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Автобусны буудал байгуулах”, БГД-т хэрэгжих 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад засварлах ажил”-ыг зураг төсөвгүй баталсан.

**ТБОНӨ-т хуулийн этгээдүүд хуульд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад баримтлах журмыг мөрдөөгүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.**

2.12 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оны эцэст тодотгол хийж худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас зарим төсөл, арга хэмжээг он дамжин хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн, төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилсөн, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зэрэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4[66]-д заасныг зөрчсөн байна.

- Монгол шуудан ХК нь 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилгын зураг, төслийн ажлыг тусгасан боловч зориулалтыг өөрчлөн Б заалны интерьерийн зураг төсвийг хийлгэхээр 12.9 сая төгрөгийн гэрээг байгуулж, урьдчилгаа 6.9 сая төгрөгийг шилжүүлсэн;
- Монгол Шуудан ХК нь 2024 онд “Хуулийн зөвлөх үйлчилгээ”, “Үйл ажиллагааны дүрэм, журам боловсруулах” ажлуудад 32.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, төлбөрийг бүрэн шилжүүлсэн боловч гэрээг дүгнээгүй байна.

[66] Төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх.

2.13 Улс, орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй төсөл, арга хэмжээг төлөвлөн баталж, газрын зөвшөөрөл олгогдоогүй байхад барилга барих санхүүжилт олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2[67]-д заасныг зөрчсөн байна. Үүнд:

- Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 2024 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Эко жорлон" төсөл, арга хэмжээг төлөвлөн баталж, хэрэгжүүлсэн;
- Эрдэнэс Монгол ХХК-ийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд газрын зөвшөөрөл олгоогүй байхад барилга барихаар 4,920.0 сая төгрөг, автомашины зогсоол барихаар 373.5 сая төгрөг, нийт 5,293.1 сая төгрөгийг тусгаж баталсан.

2.14 ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.5[68]-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй дараах аж ахуйн нэгжүүд байна.

**Хүснэгт 3.** Шууд худалдан авалт зохион байгуулсан 2022-2024 оны төлөвлөлтийн судалгаа

/сая төгрөг/

| Д/д | Байгууллагын нэр | 2022 он | | 2023 он | | 2024 он | | нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төсөв | Тоо | Төсөв | Тоо | Төсөв | Тоо | Төсөв | Тоо |
| 1 | Монгол Шуудан ХК | 867.4 | 87 | 1,008.1 | 80 | 709.1 | 21 | 2,584.6 | 188 |
| 2 | Монголын цахилгаан холбоо ХК | 1,394.0 | 104 | 811.7 | 97 | 40.0 | 3 | 2,245.7 | 204 |
| 3 | Мэдээлэл холбооны сүлжээ ХХК | 253.5 | 13 | 2,773.4 | 4 | 2,827.0 | 6 | 5,853.9 | 23 |
| 4 | Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ | - | - | 140.6 | 12 | 477.1 | 30 | 617.7 | 42 |
| 5 | Диспетчерийн үндэсний төв ХХК | | | 306.8 | 29 | 304.5 | 26 | 611.3 | 55 |
| 6 | Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК | | | 1,195.0 | 100 | 1,254.3 | 91 | 2,449.3 | 191 |
| **7** | Дулааны хоёрдугаар цахилгаан станц ТӨХК | | | 232.0 | 18 | 402.5 | 29 | 634.5 | 47 |
| **8** | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | | | 2,974.0 | 185 | 3,359.2 | 201 | 6,333.2 | 386 |
| | **ДҮН** | **2,514.9** | **204** | **9,441.6** | **525** | **9,373.7** | **407** | **21,330.2** | **1,136** |

2.15 Цахим дэлгүүрт байршуулсан бараа бүтээгдэхүүний сонголт бага, чанарын шаардлага хангаагүй, үнэ өртөг нь зах зээлийн үнээс зарим тохиолдолд өндөр байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.

2.16 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбоотой зөрчил 2023 онд буурсан хэдий ч ТЕЗ-ын удирдлага зохион байгуулалт хангалтгүй, хяналт сул байгаагаас 2024 онд зөрчил нэмэгдэж, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

[67] хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ.
[68] Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.

Дүрслэл 2.Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүд хуулийн заалтаар /сая.төгрөг/




Дүрслэл 3. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчлүүд хуулийн заалтаар /сая.төгрөг/




2.17 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг зөрчиж байгаа дээрх зөрлүүд нь төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл арга хэмжээг төлөвлөн, тодотголоор нэмж баталж, байгаагаас шалтгаалан худалдан авах ажиллагаа оройтох, хугацаандаа хэрэгжихгүй байх, он дамжин хэрэгжих нөхцөл үүсгэж байна.

2.18 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад баримтлах журмыг мөрдөөгүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, төрийн хэмнэлтийн горимыг мөрдөхгүй байна

# БҮЛЭГ 3 ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА

## Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд 2022-2024 онд Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитаар нийт 209,453.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлж, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажилласан

3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана.” гэж заасан.

3.2 Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2022 онд 61,600.0 сая төгрөг, 2023 онд 56,800.0 сая төгрөг, 2024 онд 91,053.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлэн, дүгнэлт, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулж, ажилласан байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт 9, 10-д үзүүлэв)*

Дүрслэл 4. Аудитын 2022-2024 оны илрүүлэлт /сая төгрөг/




3.3 Илрүүлсэн зөрчилд өгсөн аудитын шийдвэрийн мэдээллийг харуулбал:

**Төлбөрийн акт:**

- Аудитаар 2022 онд 581 зөрчилд 1,420.4 сая төгрөгийн, 2023 онд 248 зөрчилд 787.0 сая төгрөгийн, 2024 онд 182 зөрчилд 422.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, шалгагдагч байгууллагад хүргүүлж ажилласнаас 2023 онд тогтоосон төлбөрийн актын дүн өмнөх оноос 45.6 хувиар буурч, 2024 онд 46.4 хувиар буурсан байна.

**Албан шаардлага:**

- Аудитаар 2022 онд 928 зөрчилд 41,366.4 сая төгрөгийн, 2023 онд 343 зөрчилд 14,652.3 сая төгрөгийн, 2024 онд 355 зөрчилд 15,731.5 сая төгрөгийн албан шаардлага өгч 2023 онд тогтоосон албан шаардлагын дүн өмнөх оноос 2.8 дахин буурч, 2024 онд 7.0 хувиар өссөн байна.

**Зөвлөмж:**

- Аудитаар 2022 онд 418 зөрчилд  17,284.8 сая төгрөгийн, 2023 онд 384 зөрчилд 6,877.3 сая төгрөгийн, 2024 онд 566 зөрчилд 72,596.2 сая төгрөгийн зөвлөмжийг шалгагдагч байгууллагад хүргүүлж, зөвлөмжийн дүн 2023 онд өмнөх оноос 61.2 хувиар буурч, 2024 онд 10 дахин өссөн нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна

Дүрслэл 5.Санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн зөрчил /сая төгрөг/




| | 2022 он | 2023 он | 2024 он |
|---|---|---|---|
| Албан шаардлага | 41,366.4 | 14,652.3 | 15,731.5 |
| Зөвлөмж | 17,284.8 | 6,877.3 | 72,596.2 |
| Төлбөрийн акт | 1,420.4 | 787.0 | 422.0 |

3.4 Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 95.2 хувийн хэрэгжилттэй байна:

**Төлбөрийн акт:**

- Санхүүгийн тайлангийн аудитаар 2022 онд нийт 1,420.4 сая төгрөгийн 584 төлбөрийн акт тогтоосноос 664.7 сая төгрөгийн 444 төлбөрийн актыг барагдуулж, хэрэгжилт 46.8 хувьтай;
- Санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд нийт 787.0 сая төгрөгийн 248 төлбөрийн акт тогтоосноос 499.5 сая төгрөгийн 220 төлбөрийн актыг барагдуулж, хэрэгжилт 63.4 хувь буюу өмнөх оноос 16.6 хувиар өссөн байна.

**Албан шаардлага:**

- Санхүүгийн тайлангийн аудитаар 2022 онд нийт 41,366.4 сая төгрөгийн 928 албан шаардлага хүргүүлснээс 18,406.7 сая төгрөгийн 618 албан шаардлага буюу 44.5 хувийг хэрэгжүүлж ажилласан;
- Санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд нийт 15,731.5 сая төгрөгийн 355 албан шаардлага хүргүүлснээс 84.3 хувь буюу хэрэгжилт өмнөх оноос 39.8 хувиар өссөн байна.

**Зөвлөмж:**

- Санхүүгийн тайлангийн аудитаар 2022 онд нийт 17,284.8 сая төгрөгийн 418 зөвлөмж өгснөөс 13,686.9 сая төгрөгийн 218 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлт 79.1 хувьтай;

Санхүүгийн тайлангийн аудитаар 2023 онд нийт 6,877.3 сая төгрөгийн 384 зөвлөмж өгснөөс 6,548.4 сая төгрөгийн 177 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлт 95.2 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.5 Төрийн хэмнэлтийн тухай хуульд Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой заасан хэдий ч хэрэгжүүлээгүй, хяналт тавьж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг батлах;
- Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишиг батлах;
- Тээврийн хэрэгслийн улсын дугаар болон хязгаарлалт хяналт тавиагүй;
- Төрийн байгууллагын орон тоо, цалин хөлсний төлөвлөлт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх.

3.6 Төрийн хэмнэлтийн тухай хуульд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой заасан хэдий ч хэрэгжүүлээгүй, хяналт тавьж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавиагүй;
- Хэмнэлтийн арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх асуудлаар санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;
- Төсвийн байгууллагын зардал, арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмбэлэн төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийж санхүүжүүлэх;
- Хэмнэлтийн горимыг чанд мөрдөх үйл ажиллагааны төлөвлөлт, уялдаа холбоо, зохицуулалтыг удирдлагаар хангах, энэ талаар тухайн жилийн төсөв боловсруулах удирдамжид тусгаж, төсвийн ерөнхийлөн захирагчдад хүргүүлэх;
- Хуульд зардлын хэмжээ, тариф батлах талаар тусгайлан эрх олгогдоогүй салбарын үйлчилгээ, арга хэмжээний зардлын стандарт нормативыг холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцсөний үндсэн дээр хамтран батлах;
- Хэмнэлтийн ач холбогдлыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг арга зүй, удирдлагаар хангах.

3.7 Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага хуулийн хэрэгжилтэд хяналт тавиагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.8 Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар Засгийн газрын 2022 оны 203 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол, 204 дүгээр “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор өгсөн үүргийг хэрэгжүүлээгүй байна.

3.9 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтнууд хуульд заасан чиг үүргийн дагуу хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй.

3.10 Төсвийн байгууллага болон ТБОНӨ-т хуулийн этгээдүүдийн тайлант онд хэрэгжүүлэх төсвийн төсөл, төлөвлөгөө, батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явцад хяналт хэрэгжүүлэгч байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу хяналт хэрэгжүүлээгүй байна.

## ДҮГНЭЛТ

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Төсвийг төлөвлөх, захиран зарцуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар эдийн засаг сэргэж, төсвийн сахилга бат сайжрахын зэрэгцээ арвилан хэмнэх, нөөцийг үр ашигтай ашиглах нөхцөл бүрдэхээр байна.
2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим зүйл, заалт Төсвийн тухай хуулийн зарим зохицуулалттай давхардаж байгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлж боловсронгуй болгох шаардлагатай байна
3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас баталж, мөрдүүлэх хэм хэмжээний акт батлагдаагүйгээс хуулийг хэрэгжүүлэхэд тодорхойгүй байдлыг үүсгэж байна.
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн мөрдөхгүй байгаа нь төсвийн сахилга баттай, үр ашигтай, ил тод, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж, нийтийн хөрөнгийг үрэлгэн зарцуулах нөхцөлийг үүсгэж байна.
5. Засгийн газар болон түүний харьяа байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлээгүй, хяналт тавьж ажиллаагүйгээс төрийн байгууллагын санхүүгийн нөөцийн үр өгөөжийг бууруулж байна.
6. Засгийн газар болон ТӨБЗГ нь зарим төрийн өмчит хуулийн этгээдэд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай ижил чиг үүрэг бүхий хяналтын менежер, бүтээмж хариуцсан менежер, засаглалын менежерийн орон тоог шинээр бий болгох чиглэл өгч шийдвэр гаргасан нь уг хуулийн үзэл баримтлал, үндсэн зорилготой нийцэхгүй байна.
7. Зарим аймгийн Засаг дарга нар ЗДТГ-ын бүтэц, орон тоог батлахдаа Засгийн газраас тогтоосон хязгаарт төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тоог хамааруулахгүй байгаа нь төрийн албан хаагчийн тоо нэмэгдэх шалтгаан болсон байна.

## ЗӨВЛӨМЖ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зарим зүйл, заалт Төсвийн тухай хуулийн зарим зохицуулалттай давхардаж байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлж боловсронгуй болгох.
2. “Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-ийг батлах.
3. “Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишиг”-ийг тогтоож батлах.
4. Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлээр Хяналт, үнэлгээний үндэсний хорооны ажлын алба, Сангийн яам, Эрчим хүчний яам, Зам тээврийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрдэнэс монгол ХХК-д засаглал, ил тод байдал, комплаенсийн болон гүйцэтгэлийн үнэлгээ, дотоод аудитын хяналт хариуцсан удирдлагын чиг үүргийг бий болгож, томилон ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахаар өгсөн шийдвэрийг хүчингүй болгох.
5. Зарим аймгийн Засаг дарга нар ЗДТГ-ын бүтэц, орон тоог батлахдаа Засгийн газраас тогтоосон хязгаарт төрийн үйлчилгээний албан хаагчийн орон тоог хамааруулахгүй байгаа асуудлыг хянан үзэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4-т заасантай нийцүүлж байгууллагын орон тоо, цалин хөлсний тогтолцоог боловсронгуй болгох.
6. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, хэрэгжилтийг үнэлж, жил бүр Засгийн газарт үр дүнг тогтмол танилцуулж байх.

### САНГИЙН САЙД-д:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, биелэлт, үр дүнг тооцох;
2. ТЕЗ-дын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гэрээний хугацаа дууссан, 3-аас дээш жилийн насжилттай, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг танилцуулах;
3. Эрх бүхий албан тушаалтан худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, гэрээгүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулдаг үйлдлийг таслан зогсоож, санхүүжилтийг хэмнэлтэд тооцож, улсын төсөвт татан төвлөрүүлж байх.

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА-д:**

Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолоор өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлж, Засгийн газарт танилцуулах.

**ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ДАРГА, ЗАХИРАЛ-д:**

1. Тайлант оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд батлагдсан орон тоо, төсөв, төлөвлөгөөндөө багтаан хэмнэлтийн бодлогыг баримтлан, гүйцэтгэлд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах.
2. Зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, газрын асуудал шийдэгдсэн ажлыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, шууд худалдан авалтын тоог бууруулж, зориулалтыг өөрчлөхгүй байх.

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2025.06.16 № 02/5940

танай 2025.06.09-ны № 02/1921-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Танай газраас ирүүлсэн “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлд санал авах тухай 02/1921 тоот албан бичигтэй танилцаад холбогдох тайлбар, саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудастай

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.ГАНБАТ

Хавсралт 1

| № | Санал, тайлбар |
|---|---|
| **1. Тайлангийн нэгдүгээр бүлгийн 1.1.1-д "Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 2022-2024 оны тайлант жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй, батлагдсан төсвийг дутуу зарцуулж, улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд дараах тайлбарыг хүргүүлж байна.** | |
| 1.1 | **Засгийн газрын гадаад зээл, үнэт цаасны хүүгийн төлбөр 59.8 хувь буюу 157.6 тэрбум төгрөг;**<br><br>Дээрх 157.6 тэрбум төгрөг нь зөвхөн гадаад зээл, үнэт цаасны төлбөрөөс хэмнэгдсэн дүн биш бөгөөд 60.2 тэрбум төгрөг нь гадаад, дотоод үнэт цаасны хүүгийн төлбөрийн хэмнэлт, үлдсэн 97.4 тэрбум төгрөг нь зээлийн хүүгийн татаас болон бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний дүн байна. Мөн гадаад зээлийн хүүгийн төлбөрийн хэмнэлтийн дүн дээрх дүнд багтаагүй байна.<br><br>Гадаад, дотоод үнэт цаасны төлбөрт хэмнэгдсэн 60.2 тэрбум төгрөгийн хэмнэлт нь 2022 онд 59.0 тэрбум төгрөг, 2023 онд 0.6 тэрбум төгрөг, 2024 онд 0.6 тэрбум төгрөгийг хэмнэсэн бөгөөд 2022 оны хэмнэлт нь өрийн зохицуулалтын үйл ажиллагаа хийхээр төлөвлөж байсан боловч олон улсын нөхцөл байдлаас шалтгаалж 2023 оны 01 дүгээр сард хийсэн, мөн ханшийн зөрүүний хэмнэлттэй холбоотой бөгөөд ямар нэгэн байдлаар төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй гэх асуудал байхгүй болно. Түүнчлэн, зээлийн хүүгийн татаасны хувьд гаргасан зээлийн гүйцэтгэлтэй холбоотойгоор зардал хэмнэгддэг тул хасах саналтай байна. |
| 1.2 | **Засгийн газрын зээлийн үйлчилгээний төлбөрийн ханшийн зөрүүгийн олз, гадаад зээлийн хүүгийн төлбөрийн хэмнэлт 21.2 тэрбум төгрөг;**<br><br>Энэ хэмнэлт нь 2022 онд 13.3 тэрбум төгрөг, 2023 онд 0.2 тэрбум төгрөг, 2024 онд 7.7 тэрбум төгрөг гарсан бөгөөд 2022 онд олон улсын жишиг хөвөгч хүүгийн хэмжээ 2022 оны 02 дугаар сард 0.05 хувьтай тэнцэж байсан бол 04 дүгээр сард 0.8 хувь болж өссөн, цаашид мөн өсөх тооцоолол гарсан. Энэ өсөлт нь тооцоолсон хэмжээнээс бага байсан тул 2022 онд хэмнэлт үүссэн байна. Харин 2023-2024 оны хэмнэлт нь ханшийн сулрал төсөөлсөн хэмжээнээс бага байсантай холбоотой.<br><br>Тайлант хугацаа буюу 2022-2024 онд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрийг дутуу шилжүүлсэн, хугацаа хоцроосон асуудал байхгүй, зээлийн хуваарьт төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж барагдуулсан бөгөөд гарсан хүүгийн төлбөрийн хэмнэлт нь олон улсын зах зээлийн нөхцөл байдал, валютын ханшаас шалтгаалсан байна. Иймд гадаад, дотоод үнэт цаас, гадаад зээлийн хүүгийн зардлын хэмнэгдсэн дүнгүүдийг төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй, батлагдсан төсвийг дутуу зарцуулсан хэсгээс хасах саналтай байна. |
| 1.3 | **Ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээлийн тайлбар;**<br><br>Ковид-19 цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах зорилгоор "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө"-г хэрэгжүүлсэн бөгөөд тус төлөвлөгөөний дагуу Ажлын байрыг дэмжих зээлийн хөтөлбөрийг 2021-2022 онуудад хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн дагуу 2,000.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгохоор төлөвлөснөөс 1,965.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 25,515 иргэн, ААН-д олгож уг арга хэмжээ бүрэн хэрэгжсэн.<br><br>Дээрх хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасд 2022 онд 95.0 тэрбум төгрөгийг төсөвлөж гүйцэтгэлээр 87.1 тэрбум төгрөгийг олгож 7.9 тэрбум төгрөг хэмнэгдсэн, 2023 онд 73.7 тэрбум төгрөгийг төсөвлөж гүйцэтгэлээр 48.5 тэрбум төгрөгийг олгож 25.3 тэрбум төгрөг хэмнэгдсэн, 2024 оны төсөвт 12.1 тэрбум төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 6.4 тэрбум төгрөгийг олгож 5.7 тэрбум төгрөг тус тус хэмнэгдэж нийт дээрх 3 жилд 38.8 тэрбум төгрөг хэмнэгдсэн байна. |

| | |
|---|---|
| | Хөнгөлөлттэй зээлийн хүүгийн татаасыг тооцохдоо тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах үеийн зээлийн үлдэгдэл дүнгээс тооцдог бөгөөд татаасыг сар бүр тооцож олгохдоо зээлийн бодит үлдэгдлээс тооцож олгодог. Иймд, тухайн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгчид зээлээ эргэн төлөх хуваарийн дагуу бус урьдчилан төлсөн тохиолдолд батлагдсан төсвөөс хэмнэлт гарч улмаар зээлийн хүүгийн татаас хэмнэгдсэн тул төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүй, батлагдсан төсвийг дутуу зарцуулсан хэсгээс хасах саналтай байна. |
